



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2019 он

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь төрийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн акт болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, яамны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, байгууллагын ил тод байдал, хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч ажиллалаа.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын явцад зарим тайлан, мэдээллийн хэрэгжилтийн байдалд нэмэлт тодруулга авах, асуудал хариуцсан нэгжээс тайлбар авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулах, бататгах ажлыг гүйцэтгэв.

ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2018 оны үйл ажиллагааг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7 дугаар хавсралтын дагуу дүгнэхэд ерөнхий үнэлгээ 93.3 хувь буюу 4.67 оноотой байна.

Хүснэгт 1

Үзүүлэлт		Хувь	Оноо
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	92.2	4.61
	2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	90.3	4.52
	3.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	90.6	4.53
	4.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	97.4	4.87
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	90.8	4.54
	2.Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт	94.0	4.70
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	95.7	4.78
	2.Шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ	95.0	4.75
	3.Шударга байдлын түвшний үнэлгээ /АТГ/	-	-
	4.Хэрэглэгчийн үнэлгээ	-	-
Ерөнхий үнэлгээ		93.3	4.67

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Монгол Улсын хууль 29, Улсын Их Хурлын тогтоол 14, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол 2, Ерөнхийлөгчийн зарлиг 5, Засгийн газрын тогтоол 37, Ерөнхий Сайдын захирамж 3, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 24, Засгийн газрын албан даалгавар 13 нийт хяналтад авсан 136 зүйл заалт байна.

2018 оны жилийн эцсийн байдлаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хэрэгжүүлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг авч үзвэл:

- Монгол Улсын хууль – 94.8 хувь,
- Улсын Их Хурлын тогтоол - 100.0 хувь,
- Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол - 100.0 хувь,
- Ерөнхийлөгчийн зарлиг - 60.0 хувь,
- Засгийн газрын тогтоол – 97.5 хувь,
- Ерөнхий Сайдын захирамж - 90.0 хувь,
- Засгийн газрын хуралдааны тэмдэглэл - 98.7 хувь,
- Засгийн газрын албан даалгавар - 100 хувь байна.

Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт дунджаар 92.2 хувийн биелэлттэй хэрэгжсэн байна.

Монгол Улсын хууль, УИХ-ын шийдвэр,
Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын
шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ

Хүснэгт 2

		Бүгд	МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ЗГ-ын тогтоол	Ерөнхий сайдын захирамж	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо		136	29	15	2	5	37	3	24	12
Бүрэн хэрэгжсэн	100%	101	19	10	2	1	34	1	23	12
Хэрэгжих шатанд	70%	23	9	-	-	2	3	2	1	-
Хэрэгжилт хангалтгүй	30%	3	1	-	-	2	-	-	-	-
Хэрэгжээгүй	0%	-	-	-	-	-	-	-	-	-
Чиг үүргийн дагуу бусад яамруу шилжүүлэх		9	2	7	-	-	-	-	-	-
Биелэлтийн дундаж хувь		92.2	94.8	100.0	100.0	60.0	97.5	90.0	98.7	100.0

Салбарын эрх зүйн актын хэрэгжилтийн тайлан мэдээллийг Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн сан www.unelgee.gov.mn-д оруулан баталгаажуулсан.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

1.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 2018 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын тэргүүлэн хэрэгжүүлэх 55 зорилтын 86 арга хэмжээ тусгагдсанаас 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувийн хэрэгжилттэй 58 арга хэмжээ, 70 хувийн хэрэгжилттэй 25 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувийн хэрэгжилттэй 1, үнэлэх боломжгүй 2 арга хэмжээ тус тус байна.

Нийт үнэлгээгээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд туссан хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2018 оны жилийн эцсийн байдлаар 90.3 хувийн биелэлттэй байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын
2018 онд тэргүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээний
гүйцэтгэл /хувиар /

Хүснэгт 3

Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилт /хувиар/			
		100 %	70 %	40 %	Үнэлэх боломжгүй
55	88	58	25	1	2
Дундаж - 90.3 %					

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын
2018 онд тэргүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээний гүйцэтгэл
(үйл ажиллагааны чиглэлээр)

Хүснэгт 4

№	Чиглэлээр	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилт (хувиар)
1	Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого	1	1	70.0
2	Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого	2	2	100.0
3	Нийгмийн бодлого	51	80	91.0
4	Засаглалын бодлого	1	3	80.0
Нийт		55	86	90.3

Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан салбарын арга хэмжээг 2018 оны хагас жилийн биелэлттэй харьцуулахад 30% хувиар өссөн.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд туссан зорилтуудын жилийн эцсийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх хууль, тогтоомжийн төслүүдийг шинэчлэн боловсруулж бодлогын баримт бичгийн төслүүдийг УИХ-д өргөн барин батлуулж хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаа.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

1.3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт

Улсын Их Хурлын 2017 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэрэгжүүлэх нийт 18 зорилт, арга хэмжээ туссан байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэрэгжүүлэх нийт 18 зорилт, арга хэмжээ туссанаас 2018 оны жилийн эцсийн байдлаар үр дүнтэй хэрэгжсэн буюу 100 хувийн биелэлттэй 11, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувийн биелэлттэй 5 арга хэмжээ байна.

Засгийн газрын 2017 оны 344 дүгээр тогтоолын дагуу Эрүүл мэндийн даатгалын асуудал Эрүүл мэндийн яамны чиг үүрэгтэй холбоотойгоор 2 арга хэмжээний хэрэгжилт гараагүй бөгөөд тасарсан арга хэмжээ байхгүй байна.

Нийт үнэлгээгээр Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2018 оны жилийн эцсийн байдлаар **90.6** хувьтай байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт /хувиар/

Хүснэгт 5

Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилт /хувиар/	
		100 %	70 %
18	18	11	5
Дундаж – 90.6 %			

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт / үйл ажиллагааны чиглэлээр /

Хүснэгт 6

№	Үйл ажиллагааны чиглэл	Үнэлгээ			Арга хэмжээ	Хэрэгжилт (Хувиар)
		100	70	40		
1.	Хөдөлмөр эрхлэлт	4	2	-	6	90.0
2.	Мэргэжлийн боловсрол, сургалт	-	1	-	1	70.0
3.	Хөдөлмөрийн харилцаа	3	-	-	3	100.0
4.	Нийгмийн даатгал	1	-	-	1	100.0
5.	Хүн амын хөгжил	2	2	-	4	85.0
6.	Халамж	1	-	-	1	100.0
7.	Нийт				16	90.6

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэрэгжүүлэх нийт 18 зорилт, арга хэмжээнээс 2018 оны эхний хагас жилийн байдлаар биелэлт эрчимжүүлэх шаардлагатай 40 хувийн биелэлттэй 8 арга хэмжээний хэрэгжилт 2018 оны жилийн эцсийн байдлаар 4 арга хэмжээ 100 хувь, 4 арга хэмжээ 70 хувийн биелэлттэй байна.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх
үндсэн чиглэлийн хэрэгжилт

Үнэлгээний дүн зорилт арга хэмжээгээр:

Хүснэгт 7

д/д		Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь	
			Хагас жил	Жилийн эцэс
1	1.2	Ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийн түвшинг бууруулах	40	100
2	1.9	Үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, жижиг зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэх	40	70
3	14.1	Гэр бүл, өсвөр үе залуучуудын хөгжлийг дэмжиж, нийгмийн хамгааллын эрх зүйн орчинг боловсронгуй болгох	40	70
4	14.2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх	40	70
5	14.3	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах нарийн мэргэжлийн багш нарыг бэлтгэх, тэдний цалин, хөлс, урамшууллыг нэмэгдүүлэх, сургалтын тусгай тоног төхөөрөмж, автобустай болгох, эцэг, эхийн асаргааны зардал болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэтгэмжийг нэмэгдүүлэх	40	100
6	14.4	Даатгуулагчийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор эрүүл мэндийн даатгалын бие даасан байгууллагыг хөгжүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох	-	-
7	14.5	Монгол Улсын иргэн гадаадад, гадаадын иргэн Монгол Улсад хөдөлмөр эрхлэх, тэдний эрхийг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх	40	70
8	14.6	Мэргэжлийн боловсрол, сургалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох	70	70
9	14.7	Багш нарын цалин хөлсний ангилал, зэрэглэлийг боловсронгуй болгох бодлого хэрэгжүүлэх	70	100
10	14.8	Бичил аж ахуйн нэгж, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг зээлийн бодлогоор дэмжих	40	100
11	14.9	Их, дээд сургууль, МСҮТ төгсөгчдөд өөрт бий болгосон ур чадвартаа түшиглэн ажлын байр, орлоготой болох гарааны бизнесийн дэмжлэг үзүүлэх, тоног төхөөрөмж лизингээр олгох хөтөлбөр хэрэгжүүлэх	70	100
12	14.10	Эрүүл мэндийн даатгалын бие даасан, даатгуулагч төвтэй, орчин үеийн менежменттэй тогтолцоог бий болгох, эрүүл мэндийн даатгалын иргэдэд хүрэх үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх	-	-
13	14.11	Нийгмийн даатгалын хамрах үйлчилгээг өргөжүүлсэн тэтгэврийн даатгалын тогтолцоог шинэчлэх эрх зүйн орчинг бий болгох	40	100
14	14.12	Ахмад настны тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч ажиллах	100	100
15	14.13	Багш, эмч, эмнэлгийн ажилтаны ажлын ачаалал, ур чадвар, мэргэшил, ажлын үр дүн, онцлог, ажилласан жил, гаргасан амжилт зэргээс хамаарсан цалин, хөлс, урамшуулал олгодог шинэ тогтолцоог бий болгох	70	100
16	14.14	Төрийн албан хаагчид /эмч, багш/-ын цалин болон ахмад настны тэтгэвэр, тэтгэмжийг 2018 оноос үе шаттай нэмэгдүүлэх	70	100
17	14.15	“Хүүхдийн мөнгө”, “Цалинтай ээж” хөтөлбөрт шаардагдах зардлыг төсвийн давсан орлогоос үе шаттай нэмэгдүүлэх	100	100
18	14.16	Ажлын байр нэмэгдүүлэхэд шаардагдах санхүүжилтийн асуудлыг 2018 оноос үе шаттай хуваарилах, иргэдийн эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг нэмэгдүүлэхэд чиглэсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх	70	100
			56.9	90.6

1.4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2018 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Засгийн газрын 2018 оны 55 дугаар тогтоолоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн 23 үзүүлэлтийг баталсан. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 97.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тэдгээрийг чиглэл тус бүрээр задалбал:

- ✓ Нийгмийн халамжийн 4 үзүүлэлтийн гүйцэтгэл – 94.7 хувьтай
- ✓ Хөдөлмөрийн харилцааны 3 үзүүлэлтийн гүйцэтгэл – 100 хувьтай
- ✓ Нийгмийн даатгалын 4 үзүүлэлтийн гүйцэтгэл – 99.7 хувьтай
- ✓ Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсролын 5 үзүүлэлтийн гүйцэтгэл – 96.2 хувьтай
- ✓ Хүн амын хөгжлийн 7 үзүүлэлтийн гүйцэтгэл – 97.4 хувьтай

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2018 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн 15 үзүүлэлт зорилтот түвшиндээ бүрэн хүрч 100 хувийн гүйцэтгэлтэй, 8 үзүүлэлт 83-99 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тухайн жилд шинээр бий болсон ажлын байрны тоо 2018 оны зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2018 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийн гүйцэтгэлд дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Тус яам нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр тусгагдсан бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 2018 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүд 97.4 хувиар биелсэн байна.
2. Хэрэгжүүлсэн хууль эрх зүй, санхүү, хүний нөөцийн бодлогын үр дүнд өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд чухал үүргийг гүйцэтгэдэг ажиллагчдын цалин хөлс, өндөр насны тэтгэврийн шалгуур үзүүлэлтүүд 2018 оны зорилтод түвшиндээ бүрэн хүрсэн ба сарын дундаж цалин хөлс болон дундаж тэтгэврийн хэмжээ зорилтот түвшнээс 12.5-15.1 хувиар нэмэгдсэн байна.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн
үзүүлэлтийн биелэлт /үйл ажиллагааны чиглэлээр/

Хүснэгт 8

№	Үзүүлэлт	2017 оны суурь үзүүлэлт	2018 оны зорилтот түвшин	2018 оны гүйцэтгэл	Гүйцэтгэл ийн хувь	Үнэлгээ /хувиар/
1	Нэг ядуу өрхөд зарцуулах нийгмийн халамжийн зардал					
2	Өрхийн тоо	45,458	52.333	47.311	90.4	90
	Нийгмийн халамжийн зардал /тэрбум төгрөг/	20.4	42.20	37.6	89.1	89
	Ядуу өрхөд чиглэсэн үйлчилгээний нэр төрөл					
	Өрхийн тоо	45,458	27.500	47.311	172.0	100
	Үйлчилгээний төрлийн тоо	2	4	4	100.0	100
3	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /төг/	240,000	240.000	240.000	100.0	100
4	Сарын дундаж цалин хөлсний хэмжээ /төг/	955,900	995.500	1,120.300	112.5	100
5	Дундаж тэтгэврийн хэмжээ /төг/	340,000	325.412	374.5	115.1	100
6	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тоо /10,000 ажилчдад ногдох/	3.3	3.2	3.2	100.0	100
7	Ажиллах хүчний оролцооны түвшин /хувь/	62.4%	64	61.9	96.7	97
8	Ажилгүйдлийн түвшин /хувь/	7.3%	8	6.6	121.2	100
9	Шинээр бий болсон ажлын байрны тоо	27,824	32.500	27.146	83.5	84
10	МБСБ-д элсэгчдийн тоо	19,519	20.000	23.512	117.6	100
11	МБСБ төгсөгчдийн ажлын байртай болсон хувь	48%	55	62.3	113.3	100
12	Нийгмийн даатгалд хамрагдалтын байдал					
	Ажил олгогчийн тоо	43,273	43,851	45.593	104.0	100
	Даатгуулагчийн тоо /хүн/	843,765	831,860	917.862	110.3	100
	Сайн дурын даатгалд хамрагдалт /хүн/	196,483	196.935	194.418	98.7	99
13	Хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн хувь	4.5	5.5	6.2	112.7	100
14	Хүн амын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн хүний хувь /тухайн бүлгийн нийт хүний тоонд харьцуулсан хувь/					
	Хүүхдийн хөгжлийн ордоноор үйлчлүүлсэн хүүхдийн хувь	15.0	20	17.8	89.0	89
	Залуучуудын хөгжлийн төвийн тоо	19.0	26	32	123.1	100
	Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн залуучуудын хувь	32.4	35	41.8	119.4	100
	Ахмадын хөгжлийн ордоноор үйлчлүүлсэн ахмадын хувь	20.1	30	33.4	111.3	100
	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн гэр бүлийн эзлэх хувь	14.4	15	13.9	92.7	93
15	Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	19,974	10,721.3	13,792	128.6	100
	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2018 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийн дундаж үнэлгээ	23				97.4

**ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН
ҮНЭЛГЭЭ**

2.1. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

Яамны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-ыг баримтлан хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч ажиллалаа.

Яамны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт жилийн эцсийн байдлаар **90.8** хувьтай үнэлэгдлээ.

Үнэлгээг стратегийн зорилтын хүрээнд харуулбал:

		<i>Хүснэгт 9</i>
Д/д	Стратегийн зорилт	Биелэлтийн хувь
1	Нийгмийн хамгааллын хууль тогтоомжийн төсөл, бодлого, стратеги хөтөлбөрийн хувилбар, төслийг боловсруулах, салбарын санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн бодлогыг төлөвлөх	90.0
2	Хүн ам, түүний бүлгүүдийн хөгжлийг хангахад чиглэсэн хууль тогтоомжийн төсөл, бодлого, стратеги, хөтөлбөрийн хувилбар, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах	90.0
3	Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хууль эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх	87.5
4	Хөдөлмөр эрхлэлтийн талаарх хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэх	90.6
5	Хөдөлмөрийн харилцааны талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах	93.3
6	Хүн амын нийгмийн баталгааг хангахад чиглэсэн нийгмийн хамгааллын хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах	95.2
7	Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоодын хяналт шалгалт, аудит хийх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах	94.1
8	Мэргэжлийн боловсрол, сургалтын талаарх хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хэрэгжүүлэх	85.6
Нэгдсэн үнэлгээ		90.8

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 8 стратегийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 202 арга хэмжээ тусгагдсан. Үүнээс 147 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 50 арга хэмжээ 50-89 хувь, 5 арга хэмжээ 10-49 хувийн хэрэгжилттэй байна.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

Төлөвлөгөөнд тусгагдсан арга
хэмжээний гүйцэтгэл /чиглэлээр/

Хүснэгт 10

Чиглэл	Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ	Хэрэгжилт /хувиар/			Гүйцэтгэлийн хувь
		100 %	70%	30 %	
Бодлого төлөвлөлт	19	14	4	1	90.0
Хөдөлмөр эрхлэлт	16	11	5	-	90.6
Мэргэжлийн боловсрол	18	12	4	2	85.6
Хөдөлмөрийн харилцаа	18	14	4	-	93.3
Нийгмийн хамгаалал	27	24	2	1	95.2
Хүн амын хөгжил	36	24	12	-	90.0
ХШУДАГ	32	27	4	1	94.1
Төрийн захиргаа	36	21	15	-	87.5
ДҮН	202	147	50	5	90.8

2.2. Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт

Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төлөвлөгөөнд 2 зорилт, 5 үйл ажиллагаа туссанаас 2018 оны жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн буюу 100 хувийн биелэлттэй 4, хэрэгжих шатанд буюу 70 хувийн биелэлттэй 1 үйл ажиллагаа байна.

Нийт үнэлгээгээр Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт 2018 оны жилийн эцсийн байдлаар **94.0** хувьтай байна.

Тэдгээрийг зорилт тус бүрээр харуулбал:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хүний нөөцийг чадавхижуулах зорилтын 2 үйл ажиллагаа “**бүрэн хэрэгжсэн**” буюу шалгуур үзүүлэлт зорилтот түвшиндээ бүрэн хүрч, үр дүн гарсанаар 100 хувийн гүйцэтгэлтэйгээр,
- Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилтын 3 үйл ажиллагаа “**хэрэгжих шатанд**” буюу зохион байгуулалтын арга хэмжээ авсанаар 90.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдлээ.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

3.1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2018 оны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэллээ.

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, хүний нөөцийн ил тод байдал гэсэн 2 хэсгийн 14 шалгуур үзүүлэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 95.7 хувийн хэрэгжилттэй байна.

- ✓ Үйл ажиллагааны ил тод байдлын 9 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт - 100.0 хувьтай
- ✓ Хүний нөөцийн ил тод байдлын 5 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт – 88.0 хувьтай

1. Тус яам нь үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа олон нийтэд нээлттэй байдлаар байршуулж, нэмэлт, өөрчлөлт бүрт мэдээллийг шинэчилж ажиллаж байна.
2. Яамны вэбсайтад төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа, салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг байршуулж, тогтмол шинэчилж байна.
3. Байгууллагын сул орон тооны зар, төрийн албан хаагчийг сонгон шалгаруулсан дүн, албан хаагчийн ёс зүйн дүрэм, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр зэрэг хүний нөөцийн удирдлагатай холбоотой мэдээллийг цахим хуудсанд байршуулж, олон нийтэд ил тод байлгадаг.

3.2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний нийт 58 байгууллага сар бүр 650 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулахаас 2018 оны жилийн эцсийн байдлаар сард дунджаар 603 мэдээллийг хуулийн хугацаанд, 90 мэдээллийг хугацаа хоцроож, 12 мэдээллийг байршуулаагүй байна.

Нийт 58 байгууллагаас 43 байгууллага 2018 оны жилийн турш шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд 100 байршуулж, улирал бүр “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-д заасан хугацаанд илгээж ажилласан. Тухайлбал:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт
- Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор
- Ахмад настны үндэсний төв
- Баян-өлгий аймаг дахь МСҮТ....

2018 оны байдлаар болон ХНХЯ-ны шилэн дансны хуулийн хэрэгжилт 95 хувьтай байна.

Сар бүрийн 05-ны өдөр нийт харьяа байгууллагын шилэн дансны мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулж, илгээж буй талаар хяналт, шаардлагыг тавьж ажиллаж байна.

Жил бүр Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийдэг ба тус аудитад салбарын харьяа

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

байгууллагуудын шилэн дансны тайлан мэдээг нэгтгэн хүргүүлж, шаардлагатай байгууллагуудыг түүвэрлэн аудитад хамруулж ажилласан.

Мөн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор “Чиглэл хүргүүлэх, мэдээллийг хуулийн хугацаанд цахим хуудсанд байршуулан ажиллах, дутуу оруулсан мэдээллийг нөхөн оруулах” талаар албан бичгийг төсөл хөтөлбөрийн нэгж болон харьяа байгууллагуудад хүргүүлэн тухай бүр хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулж ажиллахыг зорьж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГЭЭР ӨГСӨН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Нэг. ДҮГНЭЛТ

Тус яам нь Засгийн газрын 2016 оны 81 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т заасан чиг үүргийн хүрээнд Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр тусгагдсан томоохон бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд анхаарч ажилласан байна. Тэдгээрээс заримыг дурьдвал:

- “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд 2018 оны 8 дугаар сарын 10-ны өдөр батлуулж Улсын Их Хурлын 2018 оны 10-р сарын 26-ны өдрийн чуулганаар батлуулсан.
- Төрийн албан хаагчдын цалинг 2018 онд нэмэгдүүлэх үндэслэл, тооцооллыг боловсруулж, багш, эмч нарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцүү буюу бага цалинтай төрийн албан хаагчдын цалинг 2018 оны 9 дүгээр сарын 1-нээс 8 хувиар нэмэгдүүлэх “Төрийн зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 264 дүгээр тогтоолын төслийг боловсруулж, батлуулсан. Энэхүү арга хэмжээнд 173.1 мянган төрийн албан хаагчид хамрагдаж, улсын төсвөөс 58.1 тэрбум төгрөг зарцуулсан.
- Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 17 дугаар тогтоолоор нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэврийн хэмжээг 155 мянган төгрөг, асаргааны тэтгэмжийг 70.000 төгрөг болгон нэмэгдүүллээ. Мөн 2019 онд нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд шаардагдах 17.2 тэрбум төгрөг, асаргааны тэтгэмжийн хэмжээг хамт нэмэгдүүлэхэд шаардагдах 3.9 тэрбум төгрөг, нийт 21.1 тэрбум төгрөгийг 2019 оны улсын төсөвт тусган батлууллаа.
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр болон цэргийн алба хаасны тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай Засгийн газрын 2018 оны 16 дугаар тогтоолыг батлуулав. Уг тогтоолын дагуу нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр болон цэргийн алба хаасны тэтгэврийн хэмжээг 27000-29000 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 280000, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 243000 төгрөгөөр шинэчлэн тогтоож 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгох арга хэмжээг зохион байгууллаа. Нийгмийн даатгалын сангаас улсын хэмжээнд 2018 онд нийт 410.9 мянган хүнд 1.6 их наяд төгрөг зарцуулсан бөгөөд тэтгэвэр нэмэгдүүлэх уг арга хэмжээнд зориулж 119,5 тэрбум төгрөгийг нэмж зарцуулсан болно. Үүнээс тэтгэврийн даатгалын сангаас 292.7 мянган хүн өндөр насны, 72.6 мянган хүн тахир дутуугийн, 21.1 мянган хүн тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 17.8 мянган хүн цэргийн алба хаасны тэтгэвэр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас 4.2 мянган хүн тахир дутуугийн, 544 хүн тэжээгчээ алдсаны тэтгэвэр тус тус авч байна.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

- Засгийн газрын мөрийн хөтөлбөрт туссан Цалинтай ээж хөтөлбөрийг 2018 оноос хэрэгжүүлэхэд шаардагдах 81.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусган хэрэгжүүлж байгаа бөгөөд 2018 оны 11 дүгээр сарын байдлаар 0-3 насны хүүхдээ асарч байгаа эхийн тэтгэмжид 154.5 мянган эх, 0-18 хүртэлх насны 3 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмжид 5900 иргэн хамрагдаж нийт 89,14 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.
- Монгол Улсын 2017 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэл, 2018 оны төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр эдийн засаг сэргэж, тогтворжих төлөвтэй байгааг харгалзан нийт хүүхдийн 80 хувьд хүүхдийн мөнгийг олгохоор УИХ-ын 2018 оны 40 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн. Энэ арга хэмжээтэй холбогдуулан нэмж шаардагдах зардлын тооцоо, 80 хувь болгох үндэслэл шаардлагын талаар холбогдох мэдээллүүдийг тухайн бүр гарган ажиллаж, сайдын 2018 оны батлагдсан төсвөөс нэмж 41.04 тэрбум төгрөг 2018 оны 4 дүгээр сараас хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийт хүүхдийн 80 хувь буюу 912.0 мянган хүүхдэд олгож байна.
- Хүн амын ядуу, эмзэг бүлэгт хүрдэг хүнсний эрхийн бичгийн хамрах хүрээг 2 дахин, мөнгөн дүнг 20 хувь нэмэгдүүлэх тооцоо судалгааг хийж, Сангийн яаманд хүргүүлсэн. Ингэснээр 2018 онд тус хөтөлбөрт 42.2 тэрбум төгрөг зарцуулж 52,3 мянган өрхийн 288,6 мянган иргэн хамрагдаж, мөнгөн дүнг нэмэгдүүлснээр хүүхдэд 8000, насанд хүрсэн иргэнд 16000 төгрөгийн хүнс тэжээлийн дэмжлэг авах боломж бүрдсэн.
- 2017 онд тэтгэвэр барьцаалсан зээлийн хүү 18 хувь байсныг 15 хувь болгон бууруулсан бөгөөд 2018 оны 01 дүгээр 05-ны өдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Монгол банк, арилжааны банкуудтай тэтгэвэр барьцаалсан зээлийн хүүг бууруулах Санамж бичиг байгуулж 15 хувь байсан зээлийн хүүг 12 хувь болгон тус тус бууруулав.
- Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад техникийн болон мэргэжлийн боловсролын түвшинд суралцаж буй бүх насны суралцагчид сар бүр 100,000 төгрөгийн тэтгэлэг олгох журмын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлээд байна.
- ХНЗГТҮХ-ны 2018 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор ХХДХ-г сард 320000 төгрөг буюу нэг цагт 1904.76 мөнгөөр шинэчлэн тогтоож 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс, сард 420000 төгрөг буюу нэг цагт 2500 төгрөг байхаар шинэчлэн тогтоож 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тус тус мөрдөхөөр шийдвэрлэв.
- МУИС-ийн нийгмийн ажлын бакалаврийн түвшний сургалтын хөтөлбөрт ордог заавал судлах 16 хичээлийн 8 хичээл буюу 50 хувийн хичээлийн агуулгад хичээл тус бүрт 15 хүртэл хувиар жендэрт суурилсан хүчирхийлэл, жендэрийн үзэл баримтлал, гэр бүлийн боловсрол, гэр бүлийн харилцааны зөрчил, зөвшилцөл, хүчирхийллийн хохирогч нарт үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээний онцлог гэх мэт сэдвүүдийг шинээр тусгаж, хичээлийн агуулгыг шинэчлэн 2018-2019 оны хичээлийн жилд оюутнуудад хичээд сонголтоор санал болгон хэрэгжүүлж байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 6 хөтөлбөрийг 2017, 2018 онд хэрэгжүүлэхээр шинэчлэн баталсан.
- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.6-д. “Монгол залуусаа сургаж дадлагажуулан ажлын байраар хангаж, гадаадаас авдаг ажиллагчдын тоог 50-иас дээш хувиар бууруулна” заалтын хүрээнд 2018 онд гадаад ажилчдын тоог 30 хувь бууруулах зорилтыг хэрэгжүүлсэнээр гадаад ажилчдын тоо 2018 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар 9741 болж 2016 онтой харьцуулахад 42 хувь, 2017 онтой харьцуулахад 20 хувиар тус тус буурлаа.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай 2017-05-18 №:2017.05.18 18.1.Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 18.1.2. залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг батлах ажлыг эрчимжүүлэх /заалт 88/
- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай 2017-05-18 №:2017.05.18 20.2. "Энэ хуулийн 20.1.4-т заасан мэдээллийн санг бүрдүүлэх журмыг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Үндэсний статистикийн хороо, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн байгууллага хамтран батлаж, залуучуудын талаар мэдээллийн сан бүрдүүлж, хөтлөх ажлын явц удаашралтай байгаа ба журмыг батлуулж, үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллах.

Хоёр. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар:

- Тайлангийн хэрэгжилтийг гаргахдаа Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 оны төлөвлөгөөнд туссан хүрэх үр дүн, түвшин бүрээр гаргах, судалгаа баримт, нотолгоонд тулгуурлан үнэн зөв тайлагнах, тайланд явцын бус үр дүнг тайлагнах
- Цаашид эрчимжүүлэн ажиллах шаардлагатай байгаа 70 хувийн биелэлттэй байгаа 3.1.19, 3.2.9, 3.2.10, 3.2.23.2, 3.2.33, 3.2.35, 3.3.4, 3.3.5, 3.3.7.3, 3.3.10, 3.3.11, 3.3.26, 3.3.28, 3.4.3.2, 5.1.6, 6.1.7, 6.9.4, 5.6.12.5, 3.3.22, 3.3.17.2, 3.4.2.6, 6.9, 3.2.23, 3.2.26, 3.2.33 арга хэмжээнүүд, мөн 2017, 2018 оны гүйцэтгэлээс ахиц гараагүй арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллах.
- 40 хувийн биелэлттэй байгаа 6.7.8 дахь зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллах
- 2017 оны тайланд хийсэн дүн шинжилгээнээс 2018 оны жилийн эцсийн гүйцэтгэлээс ахиц гараагүй арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх асуудалд анхаарч ажиллах

Гурав. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлтийн талаар:

- Зорилт, арга хэмжээний биелэлтийг хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн тайлагнах, тайланд арга хэмжээний явцыг бус үр дүнг тайлагнаж хэвших
- Зорилт, арга хэмжээ, ялангуяа хүрэх түвшинг тодорхойлохдоо бодитой, биелэгдэх боломжтойгоор төлөвлөх,
- Зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд явцын хяналт тавьж хяналт, шинжилгээ, үнэлгээнээс гаргасан дүгнэлт, зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

Дөрөв. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээний талаар:

- Үзүүлэлтүүдийг яам болон харьяа байгууллагуудын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдах арга хэмжээний хүрэх үр дүнтэй холбох, төлөвлөгөөний биелэлтийг гаргах бүрт эдгээр үзүүлэлтүүдийн хүрсэн түвшинг тодорхойлж байх.

Тав. Байгууллагын ил тод байдлын үнэлгээний талаар:

- Хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн тайлагнах, арга хэмжээний явцыг бус үр дүнг тайлагнаж хэвших
- Хэрэгжилтийн явцад хяналт тавих, үйл ажиллагааг эрчимжүүлэх, хариуцлагыг сайжруулж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах

Зургаа. Яамны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн талаар:

- Засгийн газрын 2016 оны 81 дүгээр тогтоолоор баталсан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн Үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээнд ангилж, эрэмбэлэх
- Хууль тогтоомж, төр, засгийн удирдах дээд байгууллагын бусад шийдвэрээр үүрэг болгосон ажил, үйлчилгээ болон салбарын дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрт тухайн жилд хэрэгжүүлэхээр заасан арга хэмжээг 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд бүрэн тусгах
- Нэгжийн менежерүүдийн үр дүнгийн гэрээнд туссан арга хэмжээг Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ буюу байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд бүрэн тусгах.
- Арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг хянаж, стратегийн зорилтын биелэлтийг хангахад газар, хэлтсийн удирдлагуудын зүгээс анхаарч ажиллах,
- Албан бичиг боловсруулалтын стандартыг мөрдөж утга найруулга, үг үсгийн алдаагүй хэрэгжүүлэх арга хэмжээний ард тухайн биелэлтийг ялгаж тусад нь хүснэгтээр тайлагнах.
- Хоцрогдож байгаа арга хэмжээнд цаг тухай бүрт нь хяналт тавьж, шалтгаан үр дагаврыг харгалзан асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн арга хэмжээг авч байх,
- Дунд түвшний менежерүүдийн манлайлах ур чадварыг дээшлүүлэх, тэдэнтэй байгуулах гэрээг чанаржуулах.
- Биелэлтийг бодитой, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнтэй нь уялдуулж тайлагнах, хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг бодлого төлөвлөлт, зохицуулалтад ашиглах.

---oOo---

ХАВСРАЛТУУД

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, танилцуулга
2. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээний тайлан, танилцуулга
3. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтийн үнэлгээний тайлан, танилцуулга
4. Байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайлан, танилцуулга

ТАНИЛЦСАН:

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.ӨНӨРБАЯР

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

Ц.МӨНХЗУЛ